

Албадан саатуулах болон хяналтанд авах тухай

Дараах нэр бүхий байгууллагууд цагаачлал хүсэгчдийг Гадаад иргэдийн асуудал зохицуулах актын дагуу албадан саатуулах, хяналтанд авах эрхтэй. Үүнд: Швед улсын засгийн газар, Цагаачлалын алба, Гадаад иргэдийн хэрэг эрхлэх алба болон Цагдаагийн байгууллага. Албадан саатуулагдсан болон хяналтанд орсон этгээд бусад цагаачлал хүсэгчдийн нэгэн адил өдөр тутмын мөнгөн тэтгэлэг болон эмнэлгийн тусламж авах эрхтэй.

Албадан саатуулах

Албадан саатуулагдсан этгээдийг Цагаачлалын албаны хяналтан дахь тусгай хорих байранд хорино. Эрх бүхий байгууллага цагаачлал хүсэгчтэй уулзах боломжтой байхын тулд албадан саатуулах шийдвэрийг гаргана. Насанд хүрсэн иргэдийг дараах нөхцөлд албадан саатуулна. Үүнд:

- 1) Тухайн иргэний цагаачлал хүссэн өргөдлийг бүрэн хэлэлцэхийн тулд зайлшгүй шаардлагатай бол 48 цаг хүртэл хугацаагаар албадан саатуулна.
- 2) Швед улсад зорчин орох буюу цагаачлал хүссэн өргөдлөө өгөх үед цагаачлал хүсэгч нь биеийн байцаалтгүй, өөрийгөө хэн болохын нотлон тодорхойлох боломжгүй тохиолдолд 14 хоног хүртэл хугацаагаар саатуулж болно.
- 3) Швед улсад оршин суух зөвшөөрөл олгогдохгүй нь тодорхой болсон, эсвэл тус улсыг орхин гарах нь зайлшгүй шаардлагатай гэсэн шийдвэр гарсаны улмаас тухайн цагаачлал хүсэгчийг нуугдах, оргон зайлах, хууль бус үйл ажиллагаанд оролцож болзошгүй гэж үзвэл албадан саатуулна. Оршин суух зөвшөөрөл олгогдохгүй нь

тодорхой гэж үзэх нөхцөлд албадан саатуулах хугацаа нь 14 хоногоос хэтрэх ёсгүй. Швед улсыг орхин гарах тухай шийдвэр гарсан бол 2 сар хүртэлх хугацаагаар албадан саатуулж болно.

Албадан саатуулах хугацааг зайлшгүй шаардлагатай гэж үзвэл хэлэлцсэний үндсэн дээр тодорхой хугацаагаар сунгаж болдог. [2,3-р зүйлийг харна уу.] Аюулгүй байдлыг хангах, дэг журам тогтоохын тулд албадан саатуулагдсан насанд хүрсэн иргэдийг бусад саатуулагдсан этгээдээс тусгаарлах арга хэмжээ авна. Жишээлбэл, тусгай эрх чөлөө хязгаарласан өрөө эсвэл Цагдаагийн мөрдөнд ганцаарчлан хорино.

Насанд хүрээгүй хүүхэд

Хүүхдийг эцэг эх, асран халамжлагчаас тусгаарлан хорих тохиолдолд хэн хэнийг нь албадан саатуулахыг хориглоно. Шаардлагатай гэж үзвэл эцэг эх, асран халамжлагчийн хамт насанд хүрээгүй хүүхдийг албадан саатуулах арга хэмжээг авна. Албадан саатуулах хугацаа нь 72 цаг хүртэл хорих ёстой бөгөөд зайлшгүй шаардлагатай гэж үзвэл үргэлжлүүлэн 72 цагаар дахин сунгаж болдог.

Швед улсад эцэг эх, асран халамжлагчгүйгээр ганцаараа ирсэн хүүхдийг тус улсад цагаачлал зөвшөөрөл олгоогүй болон улсыг орхин гарах шийдвэр гарсан үед тусгай нөхцөлд албадан саатуулна.

Албадан саатуулагдсан этгээдийн эдлэх эрх
Албадан саатуулах газрын байр нь Цагаачлалын албанаас цагаачлал хүсэгчдэд олгодог байртай тодорхой хэмжээгээр адил төстэй байдаг.

Үүнд: байрнаас гадагш гаргаж салхилуулах, эргэлт хүлээн авах, бусад зохион байгуулах үйл ажиллагаанд оролцох эрх эдэлнэ.

Албадан саатуулагдсан этгээдэд тусламж дэмжлэг үзүүлэх хүсэлтэй олон нийтийн сайн дурын байгууллагууд, сүм болон шашны байгууллагуудтай Цагаачлалын байгууллага нь хамтран ажиллана. Тус албадан саатуулах газрын ажилчид өөрсдийн үйл ажиллагааны талаар тодорхой танилцуулах болно.

Ажилчидын үүрэг хариуцлага

Албадан саатуулах газрын ажилчид 24 цагаар ажилладаг тул тусламж дэмжлэг хэрэгтэй үед тэдэнд хандаж болно. Албадан саатуулах байрны ажилчид тус байрны аюулгүй байдлыг хангах, хянах үүрэгтэй байх болно.

Албадан саатуулагдах хугацааг нь аль болох багасгахын тулд тухайн саатуулагдсан этгээд тус байрны ажилчидтай хамтран ажиллах нь чухал. Жишээлбэл, цагаачлал хүссэн өргөдлийг хэлэлцэхэд шаардагдах бичиг баримтыг цаг тухайд нь бүрдүүлэн олж, авчирч үзүүлвэл зохино.

Швед улсаас буцаж байгаа иргэдэд туслах, буцах шийдвэрээ хүлээн авсан болон оршин суух зөвшөөрөлгүй иргэдийг тус улсаас гаргах үйл ажиллагааг тус газрын ажилчид хариуцан ажиллана.

Эдгээр буцаагдаж буй иргэд ар гэртэйгээ холбоо барихад тус газрын ажилчид болон нийгийн сайн дурын байгууллагын ажилчид туслах болно.

Хяналтанд авах

Тухайн цагаачлал хүсэгчийг албадан саатуулах

үндэслэл шалтгаангүй гэсэн нөхцөлд хяналтанд авах хангалттай гэж үздэг. Мөн түүнчлэн насанд хүрээгүй хүүхдийг тусгай нөхцөлд хяналтан дор байлгана.

Хяналтанд орсон этгээд Цагаачлалын алба болон орон нутгийн цагдаагийн газар тодорхой өгөгдсөн хугацаанд тогтмол ирж бүртгүүлэх эсвэл биеийн байцаалт, бусад бичиг баримтаа хураалгахаас гадна бусад онцгой шаардлагыг хангах ёстой. Цаашид хяналтанд авах шаардлагагүй гэж үзвэл хяналтанд байлгах шийдвэрийг хүчингүй болгоно.

Хүчингүй болгоогүй нөхцөлд тус шийдвэрийг 6 сар тутамд дахин хэлэлцэнэ.

Хууль эрх зүйн зөвлөгч, өмгөөлөгч

Цагаачлал хүсэгчийн хэргийг хэлэлцэх хугацаанд хууль эрх зүйн тусламж хэрэгцээтэй гэж дүгнэвэл Цагаачлалын албанаас хуулийн зөвлөгчийг төлбөргүй тусламж өгөх нөхцөлийг бүрдүүлэн томилдог.

Энэхүү хуулийн зөвлөгч нь зөвхөн тухайн иргэний эрх ашгийн төлөө Цагаачлалын алба болон бусад эрх бүхий байгууллагаас хараат бус үйл ажиллагаа явуулдаг бөгөөд цагаачлал хүсэгчийн өргөдөл-асуудлыг хууль эрх зүйн хүрээнд хэлэлцэгдэж байгаа эсхийг хянаж шалгадаг.

Шийдвэрийг даван заалдах

Албадан саатуулах шийдвэрийг орон нутгийн захиргааны шүүхэд давж заалдаж болдог. Давж заалдсан өргөдлийг Цагаачлалын албанд гаргахад тус алба шүүхэд хүргүүлнэ. Хяналтанд авсан шийдвэр гарсан тохиолдолд цагаачлал хүсэгч нь давж заалдах эрхгүй.